



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



"ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД"

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс уламжлал болгон зохион байгуулдаг “Зоонозын өвчний тулгамдсан асуудлууд” сэдэвт олон улсын хуралд оролцохыг урьж байна.

2017 оны 07 сарын 05



Зохион байгуулагч

Эрүүл мэндийн яамны харъяа Зоонозын өвчин судлалын үндэсний төв

"ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын мэдээлэл

Хамрах сэдэв: Зоонозын халдварт өвчний (Тарваган тахал, боом, галзуу, хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, шувууны томуу, баруун нилийн халуурал, хулгана тахал зэрэг) шалтгаан судлал, тархвар судлал, эпизоот судлал, нян судлал, молекул биологи, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт.

Хуралд оролцох хэлбэр

- Өгүүлэл хэвлүүлэх
- Илтгэл хэлэлцүүлэх (аман болон ханын)

Өгүүлэлд тавигдах шаардлага:

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлэх өгүүллийг дараах шаардлагын дагуу бэлтгэсэн байна. Үүнд:

1. Бүтээлд хэвлүүлэх өгүүллийг 5-10 хуудсанд багтааж, үсгийн фонд Times New Roman 12, мөр хоорондын зай 1, дээрээс 2.5см, доороос 2см, зүүн талаас 3см, баруун талаас 1.5см зай авч бичнэ.
2. Өгүүлэл бичих ерөнхий стандартыг хангасан, өгүүллийн эхэнд гарчиг, зохиогчийн нэр, зохиогчийн харъяалагдах албан байгууллагын нэр, E-mail хаяг, түлхүүр үгсийг бичнэ. Өгүүллийн үндсэн бичиглэл нь удиртгал, материал, арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, ном зүйн жагсаалт гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Өгүүллийн хураангуйг 350 үгэнд багтаан Монгол, Англи хэл дээр хийсэн байна.
3. Биологи, хими, анагаахын шинжлэх ухааны нийтээр зөвшөөрөгдсөн нэршил, хэмжигдэхүүнээс бусад нэр, нэршилийг товчлохгүй, олон улсын нэр томъёо хэрэглэсэн байна. Хэмжих нэгжүүд нь СИ системээр бичигдсэн байна.
4. Анагаахын нэр томъёог П.Нямдаваа нарын "Анагаах ухааны Монгол нэр томъёоны англи, герман, латин, орос, франц хэлээр хадмал орчуулгатай товч тайлбар толь"-д байгаагаар буюу уг тольд байхгүй үгийг уг тольд баримтласан зарчмын дагуу бичнэ.
5. Илтгэл, өгүүлэлд нэр томъёог товчилж бичихгүй, амьтан, шимэгч, бичил биетний зүйлийг бичихдээ эхний удаа бүтэн нэрээр, дараа нь товчлон бичиж болно. Жишээ нь *Oropsylla silantiewi*, цаашид дахин давтагдах тохиолдолд *O.salantiewi* гэж бичнэ. Латин нэрийг налуу (Italic)-аар бичнэ.
6. Биоанагаахын ёс зүйн асуудлыг зохицуулж, ёс зүйн зөвшөөрлийг авсан байна.
7. Илтгэл, өгүүллийг өөрсдийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн бичих бөгөөд нийтлүүлэхийг зөвшөөрсөн эрдэм шинжилгээний удирдагчийн зөвшөөрөл буюу байгууллагын захирал, эрхлэгчийн албан бичигтэйгээр ирүүлнэ.
8. Зураг, график нь зөв оновчтой сонгосон, үр дүнгийн бичиглэл хэсгийг шууд давтаагүй, босоо, хэвтээ тэнхлэгийн утга, хэмжих нэгжийг зөв томъёолж бичсэн

байна. Зураг, дүрслэлийн дугаар, нэрийг тухайн зургийн дор оруулна. Зургийн эх хувийг JPEG файлаар хавсралтаар явуулна. Хүснэгтийн нэр, дугаарыг тухайн хүснэгтийн баруун дээд буланд бичнэ.

9. Өгүүлэлд ном зүйн ишлэл оруулахдаа дөрвөлжин хаалтанд ном зүйн жагсаалт дах дугаарыг тавина. Ном зүйн жагсаалтыг зохиогчийн үсгийн дарааллаар эсвэл бүтээлд иш татсан дарааллаар АРА загварын дагуу оруулна.

Өгүүлэл иш татах: Отгонбаатар, Д. Цоодол, С. (2006). Галзуу өвчний тархвар зүйн онцлог. *Монголын анагаах ухаан*, № 2, Х.12-15.

Ном, нэг сэдэвт зохиол, эмхтгэлээс иш татах:

Адъяасүрэн, З. (1994): “Монгол алтайн зүүн өмнөд хэсгийн тарваган тахлын байгалийн голомтын халдвар тархалтын чадамж. Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээл, улаанбаатар, х.65-66.

Хэвлэгдсэн илтгэлийн товчлолыг иш татах жишээ:

Ганболд, Д., Банди, М., Ариунсанаа, Б. (2006). Хүний ку халуурал өвчний оношлогооны асуудалд, БГХӨЭС Төв эрдэм шинжилгээний бүтээл, Улаанбаатар, эмхэтгэлд, х.176-182.

Он-лайн материалыг иш татах жишээ:

Нямдаваа, П. Томуугын А(Н7N9) вирүст халдварын тухай мэдээ: 31/13,

http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=1136&itemid=49, accessed on dec.11, 2013;

10. Редакцийн зөвлөл зохиогчтой тохиролцсоны үндсэн дээр илтгэл, өгүүлэлд зарчмын засвар хийх, хэмжээг багасгах эрх эдэлнэ. Зохиогчид засварлах хугацаа зааж буцааж болох ба хугацаандаа ирээгүй илтгэл өгүүллийг хэвлэхгүй.
11. Урьд нь бусад хэвлэлд хэвлэгдсэн, хэвлүүлэхээр илгээсэн болон шаардлагад нийцээгүй илтгэл, өгүүллийг редакци хүлээн авахгүй.
12. Зохиогч илтгэлээ хэлэлцүүлэх санал ирүүлээгүй ч хэвлүүлэхээр ирүүлсэн өгүүлүүдээс хэлэлцүүлэх илтгэлийг редакцийн зөвлөл сонгоно.
13. Зохиогч өөрийн илтгэл, өгүүллийн бүтэц, загвар, үнэн бодит байдал ба хураангуйн орчуулгын талаарх хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Материал хүлээж авах хугацаа: Дээрх шаардлагын дагуу боловсруулсан өгүүллийг 2017 оны 04 сарын 30-ны өдрийн дотор үнэн зөв бөглөсөн бүртгэлийн хамт дараах хаягаар хүлээж авна.

Монгол улс, Улаанбаатар хот, 18131 Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэнд, сургалт, эрдэм шинжилгээний алба.

Утас: (976)-70282853, (976)-99040664

Факс: (976)-70282859

И-майл: altantogtoh@gmail.com